

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ТАНИЛЦУУЛГА

2021 оны 03 дугаар сарын 10

№

Улаанбаатар хот

ГХЯ-ны 2020 оны гүйцэтгэлийн
тайлангийн тухай

Гадаад харилцааны яамны 2020 оны гүйцэтгэлийн тайлан /гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт/-д Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний шинэчлэгдсэн “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.1, 3.2.2-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бодлогын бичигт баримт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирсэн 2017 оны 89 дүгээр тогтоолын журам 2020 оны 12 дугаар сард хүчингүй болж, 2021 оноос бодлогын баримт бичигт энэхүү 206 дугаар тогтоолын шинэчлэгдсэн журмын дагуу үнэлгээг хийх шийдвэр гарсан болно.

Шинэчлэгдсэн журамд гадаад хүчин зүйлээс шалтгаалж хэрэгжээгүй, эсвэл хэрэгжилт нь хойшилсон зарим нэг ажил, арга хэмжээнд өмнөх журмаар өгдөг байсан “үнэлэх боломжгүй” гэсэн үнэлгээ байхгүй болж, ковид-19 цар тахал зэрэг аливаа бусад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжээгүй аливаа айлчлал, арга хэмжээг 0, 30, 50 гэсэн аргачлалаар үнэлэх болсноор ГХЯ-ны 2020 оны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ нэлээдгүй буурч гарч байгааг энд тэмдэглэх нь зүйтэй гэж үзэв.

Иймд цаашид яамны бүх газар нэгжүүд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилт бүр дээр тодорхой үр дүн гаргаж, чармайн ажиллах шаардлага бий болж байна.

Төрийн яам, агентлагууд 2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг анх удаа цоо шинэ загвараар, чингэхдээ төлөвлөгөөнд арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин, санхүүжилтийг тодорхой тусгах шийдвэр гарсантай холбогдон тус яам цаг хугацаанд баригдан яаравчлан боловсруулсанаас үүдэн ажил, арга хэмжээний санхүүжилт, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг дутуу гаргах, шалгуур үзүүлэлтийг буруу бичих зэрэг тохиолдол гарсныг тэмдэглэж байна.

Мөн 2020 оны эцэст Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол¹-ын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг дахин шинэ загвараар төлөвлөж, боловсруулах шийдвэр

¹ “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай” гэж заасан.

гарсан тул цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2.1-ийн 2.1.7-2.1.9 дэх заалтын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг зөв тодорхойлж, ЗГХЭГ-ын даргын “Аргачлал, загвар батлах тухай” 2020 оны 100 дугаар тушаалыг баримтлахыг зөвлөмж болгож байна.

ГХЯ-ны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт **231 ажил, арга хэмжээ** тусгагдсан.

Төлөвлөгөөний биелэлт **85.0** хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй гарч байна.

Биелэлтийг дор хувиар үзүүлэв.

| № | Биелэлтийн дүн хувиар /Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын журмын дагуу арга хэмжээний дундаж үнэлгээгээр зорилтын хэрэгжилтийг дүгнэх ангилал/ | Төлөвлөсөн ажил, арга хэмжээний тоо |
|---------------------------------------|---|-------------------------------------|
| 1. | Үр дүнтэй (100 хувь) | 108 |
| 2. | Тодорхой үр дүнд хүрсэн (70-99 хувь) | 100 |
| 2. | Эрчимжүүлэх шаардлагатай (31-69 хүртэл хувь) | 18 |
| 4. | Үр дүнгүй (0-30 хүртэл хувь) | 5 |
| <u>Нийт арга хэмжээний тоо</u> | | <u>231</u> |
| Хэрэгжилт /хувиар/ | | 85.0 хувь |

Газар, нэгж тус бүрийн хариуцсан ажил, арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувийг дор үзүүлэв.

| № | Газар, нэгж | Үнэлгээ | | | | | | Нийт | Дундаж үнэлгээ |
|-------------|-------------|------------|-----------|-----------|-----------|----------|----------|------------|----------------|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |
| 1. | БТГ | 14 | 3 | 2 | 2 | - | - | 21 | 91.0 |
| 2. | ХөОГ | 7 | 5 | 3 | 3 | - | - | 18 | 83.9 |
| 3. | ЕГ | 5 | 6 | 16 | - | - | - | 27 | 80.0 |
| 4. | АНДОГ | 13 | 3 | 2 | 4 | - | - | 22 | 86.8 |
| 5. | АОДАГ | 11 | 3 | 4 | - | 1 | - | 19 | 88.4 |
| 6. | ОТХАГ | 2 | 1 | 4 | - | - | - | 7 | 81.4 |
| 7. | ГХЭЗХАГ | 10 | 9 | 7 | 5 | - | - | 31 | 82.3 |
| 8. | ТЗУГ | 16 | 2 | 5 | 2 | - | - | 25 | 89.2 |
| 9. | ОУГЭЗГ | 15 | 6 | 8 | 2 | - | - | 31 | 87.1 |
| 10. | КГ | 1 | 3 | 7 | - | - | - | 11 | 78.2 |
| 11. | ГССХГ | 4 | - | 1 | - | - | - | 5 | 94.0 |
| 12. | ДЁГ | - | - | - | - | - | - | - | - |
| 13. | ХШУДАГ | 10 | - | - | - | 3 | 1 | 14 | 77.9 |
| НИЙТ | | 108 | 41 | 59 | 18 | 4 | 1 | 231 | 85.0 |

Энд үнэлгээ харьцангуй зөрөөтэй байгаа, тухайлбал биелэлт нь 94.0 хувьтай байгаа ГССХГ-ын ажил арга хэмжээ, ажил, арга хэмжээний биелэлтийн хувь нь 78.2 хувьтай гарсан КГ, мөн ДЁГ-ын байдлыг тайлбарлах нь зүйтэй гэж үзэв.

Консулын газар яамны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ОХУ, БНХАУ, БНСУ, БНТУ, БНЧУ, БНКаЗУ-тай консулын ээлжит зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, гадаад улсад визийн төв байгуулах тухай зэрэг 7 ажлыг тусгасан боловч эдгээр арга хэмжээ цар тахлын улмаас хойшлогдсон байна. Консулын газар эдгээр ажил арга хэмжээний биелэлтийг гаргахдаа “ ... эдгээр орны төлөөлөгчдийг Монгол Улсад зохион байгуулагдах “Дэлхийн консулын форум”-ын 4 дүгээр уулзалтад оролцуулахаар бэлтгэлийг хангаж байсан ч цар тахлын үед дээрх улс орнуудын төрийн байгууллагууд бүрэн бүрэлдэхүүнээр ажиллахгүй, мөн дээрх улсын ГХЯ-ны Консулын газрууд өндөр ачаалалтай ажиллаж байгаа зэргээс шалтгаалан хойшлогдож байна “ гээд “ үнэлэх боломжгүй” үнэлгээг өгсөн байв.

Цар тахлын үеийн Консулын газрын ажлын ачаалал, хариуцлага, чармайлт, мөн консулын зөвлөлдөх уулзалтын бэлтгэлийн хангасан байдлыг харгалзан үзэж “үнэлэх боломжгүй” гэсэн үнэлгээтэй дээрх 7 ажил, арга хэмжээнд шинэчлэгдэн батлагдсан Засгийн газрын 206 дугаар тогтоолын журмын 6.2.2.3-д “ тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь,” гэж заасныг харгалзан 70 хувийн үнэлгээг өгөв.

ГССХГ-ын тухайд 100 хувийн үнэлгээ авсан 4 ажил, арга хэмжээ байгаа ба эдгээр ажил, арга хэмжээний биелэлт нь Гадаад харилцааны сайдын зөвлөлд танилцуулагдаж, бүрэн биелэгдсэн гэсэн үнэлгээтэй ЗГХЭГ-т тогтсон хугацаанд хүргүүлсэн ажил, арга хэмжээ байсан болно.

ДЭГ-ын хувьд 2020 оны өндөр, дээд түвшний айлчлалын төлөвлөгөө, зөвлөмж оройтож батлагдсантай холбогдон яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нууцын зэрэглэлтэй өндөр, дээд түвшний айлчлалыг хэрэгжүүлэх, зохион байгуулах асуудлыг тусгайлан тусгаагүй байна. Харин ДЭГ нь газрынхаа 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын 21 ажил, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж ажилласан байна.

Хэдийгээр 2020 оны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэ загвараар анх удаа боловсруулсан ч төлөвлөгөөнд ажил арга хэмжээний хэрэгжилтийг хариуцах газар, нэгжийн нэрийг тодорхой зааж бичилгүй орхигдуулсан нь газар нэгжүүдийн хариуцаж буй ажил, арга хэмжээний тоо, хувийг гаргахад хүндрэл учруулж байгааг цаашид анхаарахыг зөвлөж байна.

Мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажил арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт /Жишээ нь, төлөвлөгөөний 1.37.9, 1.38.1, 1.38.2, 1.39.1, 1.41.3-д туссан ажил, арга хэмжээ зэрэг /-ийг шаардлагын дагуу тоон үзүүлэлтээр бүрэн илэрхийлэхгүйгээр хэт ерөнхийлсөн, ажил, арга хэмжээний зардлыг СЭЗХ-тэй зөвлөлдөж, хянуулахгүй бодит бусаар төсөвлөсөн зэрэг байдал ажиглагдсан болно.

Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолын хавсралт журмын дагуу тухайн байгууллага

ажлын зорилт, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, арга хэмжээний санхүүжилтийг зөв бодитой төлөвлөх нь хэрэгжилт чанартай, үр дүнд хүрэх боломжтой юм.

Иймд ГХЯ-ны 2020 оны гүйцэтгэлийн тайлан /гүйцэтгэлийн төлөвлөгөө/-гийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:


1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын журмын дагуу гадаад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжилт нь тасарсан, хойшилсон аливаа ажил, арга хэмжээг 0, 30, 50 хувиар үнэлэх шийдвэр гарсан тул цаашид цар тахал зэрэг гэнэтийн шинэ нөхцөл байдалд дасан зохицож, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө шинэ арга зам, боломжийг эрэлхийлэх, цахим хэлбэрийг бүрэн ашиглаж, ажлыг урагшлуулах чиглэлд чармайлт гаргах;

2. Газар, нэгжүүд жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ГХЯ-ны 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөтэй нягт уялдуулж төлөвлөх, хэрэгжилтэд анхаарах;

3. Мөн жил бүрийн төлөвлөгөөнд тусгах ажил, арга хэмжээний санхүүжилтийг СЭЗХ-тэй зөвлөлдөн шаардагдах хөрөнгийг бодитой төсөвлөж, хэрэгжилтийг хангахад анхаарах.

ТАНИЛЦСАН:

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД



Б.БАТЦЭЦЭГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ДЭД САЙД

Н.МӨНХЖИН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.АНХБАЯР

ХЯНАСАН:


ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Б.БАЯРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДЭД ЗАХИРАЛ



Л.ЭРДЭНЭДАВАА